




**ХАРИЛЦАГЧ МЭДЭЭЛЛЭЭ  
ШИНЭЧЛЭЭГҮЙГЭЭС ҮҮСЭХ  
ЭРСДЭЛИЙН ЗӨВЛӨМЖ**



## ХАРИЛЦАГЧ МЭДЭЭЛЛЭЭ ШИНЭЧЛЭЭГҮЙГЭЭС ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

Банк нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 5.11-д зааснаар харилцагчийн мэдээлэлд байнгын хяналт тавьж, өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллийг шинэчлэх үүргийг хүлээдэг. Түүнчлэн, эрхэм харилцагч таньд тохирсон банкны үйлчилгээг тасралтгүй, түргэн шуурхай хүргэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамгаалахад мэдээлэл шинэчлэлийн гол зорилго оршдог билээ.

### ЯАГААД МЭДЭЭЛЛЭЭ ШИНЭЧЛЭХ НЬ ЧУХАЛ ВЭ?

- Банк, харилцагчийн талаар үнэн, зөв мэдээлэл суурилсан судалгаа хийж бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ;
- Банк, харилцагчид хурдан, шуурхай, зөв сувгаар мэдээлэл хүргүүлж чадна;
- Банк, харилцагчаа аливаа залилан, санхүүгийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах боломжийг нэмэгдүүлнэ;

### МЭДЭЭЛЛЭЭ ХЭРХЭН ШИНЭЧЛҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ВЭ?



Харилцагч салбарт ирж мэдээллээ шинэчлүүлэх. Та салбарт өөрийн биеэр ирснээр банканд бүртгэлтэй бүх төрлийн мэдээллээ шинэчлэх боломжтой байдаг.



Харилцагч лавлах төв буюу Call center (Харилцагчийн мэдээллийн хэлтэс)-т холбогдож мэдээллээ шинэчлүүлэх. Энэ тохиолдолд, хууль, журмын шаардлага болон мэдээллийн эмзэг байдлаас хамааран таны шинэчилж болох мэдээлэл хязгаарлагдмал байхыг анхаарна уу.

## МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭЛТ ХИЙГЭЭГҮЙГЭЭС ҮҮСЭЖ БОЛОХ ЭРСДЭЛИЙН ТУХАЙ

Харилцагч та мэдээллээ шинэчлээгүй, мэдээлэл хуучирсны улмаас дараах эрсдэл, асуудлууд үүсдэг. Үүнд:

- Банк хуулиар хүлээсэн үүргийн дагуу харилцагчийг таньж мэдэх ажиллагаа хийхэд хүндрэл учрах, таниас байн байн мэдээлэл шинэчлэхийг шаардах
- Харилцагчийн дотоодын болон гадаад гүйлгээ саатах, цуцлагдах
- Харилцагч гуравдагч этгээдийн халдлага болон залилан, луйврын гэмт хэрэгт өртөх
- Харилцагч өөрт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээгээ авч чадахгүй байх эрсдэлийг хүлээх
- Харилцагч цаг тухай бүрд нь банкнаас мэдээлэл авч чадахгүй байх



Мөн банк нь мэдээлэл шинэчлэлт огт хийгээгүй, банканд шаардлагатай мэдээллээ гаргаж өгөхгүй, худал мэдээлэл өгсөн тохиолдолд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль”-ийн 5.4-д заасны дагуу банк харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэг хүлээсэн байдаг билээ.



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

---

### **ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:**

**Утас:** +976 1900-1977 (дотоотоос)  
+976 7016-1988 (гадаадаас)

**И-мэйл:** [info@tdbm.mn](mailto:info@tdbm.mn)

**Вэб хаяг:** [www.tdbm.mn](http://www.tdbm.mn)